



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/291

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор баталсан “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг сайжруулах зорилгоор багийн эмчийн цомгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар баталсан багийн эмчийн цомгийн жагсаалтад орсон багаж, төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын зардлыг жил бүрийн төсөвт шат дараатай тусгаж, бэлэн байдлыг ханган ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буюнжаргал)-т даалгасугай.

САЙД



Д. САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal

141201022

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
сарын . 15 . ны өдрийн дугаар
тушаалын хавсралт *1/29*

БАГИЙН ЭМЧИЙН ЦОМГИЙН ЖАГСААЛТ

Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	Тоо хэмжээ
1. Таблет	1
2. Цэнэглэгч батерей	1
3. Гар чийдэн /гэрэл гаргагч, дуу гаргагч дохио өгөх зориулалтын/	1
Эмнэлгийн хэрэгсэл:	
4. Даралтын аппарат /Электрон/	1
5. Чагнуур	1
6. Ургийн модон чагнуур	1
7. Чихний дуран	15
8. Туузан метр	2
9. Сахар хэмжигч	1
10. Холестрин хэмжигч	1
11. Өндөр, жин хэмжигч	1
12. Нярайн жин хэмжигч	1
13. Пульсоксиметр	Хүүхдийн – 2, Том хүний - 2
14. Даралтын аппарат /Электрон/	1
15. Амьсгал тоологч	1
16. Халуун хэмжигч	5
17. Бумба	2 багц
18. Хэл дарагч	50
19. Жирэмсний хугацаа тодорхойлох хүрд	2
20. Чангалуур (резинэн)	3
21. Боолтын материалууд (сунамтгай, наалддаггүй)	5
22. Шүд угаах сургалтын муляж сойзны хамт	1
Оношлуур	
1. Жирэмсний хурдавчилсан туузан оношлуур	30
2. ХДХВ/ДОХ-ийн оношлуур	30
3. Тэмбүүгийн оношлуур	50
4. Шээсний хурдавчилсан туузан оношлуур /өнгөөр заадаг/	50
5. Гемоглобины хурдавчилсан туузан оношлуур	50
Сургалтын хэрэгсэл: Багц	
1. Сургалт сурталчилгаанд ашиглах дүрстэй мэдээлэл, самбар, биет үзүүлэн	Багцаар
2. Гарын авлага, материал (эвхмэл, календарь г.м)	Багцаар
Цүнх:	
1. Эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын цүнх 30x40 см хэмжээтэй, олон таславчтай	Цүнх нь : -Норох, гэмтэх зэрэг гадны таагүй хүчин зүйлсээс хамгаалагдсан -Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх боломж бүхий ариун, бохир материалыг ангилан хийхэд зориулагдсан тусгаарлагчтай -Угааж, цэвэрлэх, ариутгах, дахин хэрэглэх боломжтой